

ҮНЭТ ЦААСНЫ ДОТООД МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙГ
ЭЗЭМШИГЧЭЭС ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР
ЯВУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаасны хорооноос /цаашид "Хороо" гэх/ үнэт цаасны дотоод мэдээлэл/цаашид "дотоод мэдээлэл" гэх/ болон түүнийг эзэмшигчийг тогтоох, үнэт цаасны зах зээл дээр дотоод мэдээлэл эзэмшигчээс явуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. "Дотоод мэдээлэл" гэж үнэт цаасны ханшид нөлөөлж болох, үнэт цаасны арилжаанд оролцоход давуу тал олгох, түүнчлэн энэ журмаар дотоод мэдээлэл гэж тогтоосон нийтэд тарагдаагүй мэдээллийг хэлнэ.

1.3. "Дотоод мэдээлэл эзэмшигч" гэж үнэт цаас гаргаж байгаа хувьцаат компанийн эрх бүхий албан тушаалтан болон эрхэлж байгаа ажил, албан тушаалын дагуу үнэ цаас гаргагчийн талаар нийтэд тараагдаагүй мэдээлэл эзэмшигч, түүнчлэн энэ журмаар дотоод мэдээлэл эзэмшигчээр тогтоосон этгээдийг хэлнэ.

1.4. Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагч, үнэт цаасны арилжаа эрхлэх болон үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын эрх бүхий ажилтан эрхэлж байгаа ажил үүргийн дагуу үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчдийн талаархи мэдээллийг гаргуулан авах, түүнтэй танилцах эрхтэй.

ХОЁР. Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигч этгээд

2.1. Дотоод мэдээлэлд дараахь мэдээлэл хамаарна:

2.1.1. Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн бүртгэл/хувьцаа эзэмшигчийн овог, нэр, түүний өмчлөлд буй үнэт цаасны тоо, оршин суугаа хаяг/;

2.1.2. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага дахь харилцагчийн үндсэн болон холболтын дансны дугаар, дансад нь байгаа үнэт цаасны тоо, мөнгөн хөрөнгийн хэмжээ;

2.1.3. Брокер, дилерийн компанитай байгуулсан харилцагчийн гэрээ, үнэт цаас эзэмшигчийн үнэт цаасны зах зээлд ажиллах бодлого, зорилго, үйл ажиллагаатай холбогдсон мэдээ, баримт;

2.1.4. Хувьцаат компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой нийтэд тараагдаагүй болон компанийн дүрмээр нууц гэж тогтоосон мэдээ, баримт;

2.1.5. Үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд Хорооноос болон эрх бүхий байгууллагаас хийсэн шалгалтын тайлан, бусад материалд орсон нийтэд тараагдаагүй мэдээ баримт;

2.1.6. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа явуулахад хэрэглэдэг тооцоолох машины санах байгууламжид агуулж байгаа мэдээ;

2.1.7. Үнэт цаасны бүртгэл, судалгааны файлд байгаа мэдээ, анхан шатны баримт болон албан ажлын хэрэгцээнд зориулсан тайлан, мэдээ, судалгаа;

2.1.8. Үнэт цаасны арилжааны гүйлгээний мэдээ, дансны хуулга.

2.2. Дотоод мэдээлэл эзэмшигчид дараахь этгээд хамаарна:

2.2.1. Компанийн тухай хуулийн 81.1-д заасан хувьцаат компанийн эрх бүхий албан тушаалтан, Хянан шалгах зөвлөлийн гишүүн/хянан шалгагч/, бүртгэл, санхүүгийн болон архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан;

2.2.2. Хувьцаат компанийн нийт гаргасан үнэт цаасны багцыг/гуравны нэг/ эзэмшигч;

2.2.3. Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа явуулахад хэрэглэдэг тооцоолох машины санах байгууламжид хадгалагдаж байгаа

мэдээг сүлжээнд оруулах, боловсруулах, хадгалах, танилцах ажлыг ажил үүргийн дагуу гүйцэтгэж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа явуулах байгууллагын эрх бүхий албан тушаалтан, ажилтан;

2.2.4. Зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг брокер, дилерийн компанийн менежер, дилер, брокер, тэдгээрийн итгэмжлэгдсэн этгээд;

2.2.5. Хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэл судалгааг ажил үүргийн дагуу хариуцдаг арилжаа эрхлэх байгууллагын ажилтан;

2.2.6. Үнэт цаасны хорооны гишүүн, Ажлын албаны мэргэжилтэн, үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагч.

ГУРАВ. Дотоод мэдээлэл

эзэмшигчийн үүрэг

3.1. Дотоод мэдээлэл эзэмшигч нь дараахь үүрэгтэй байна:

3.1.1. Үнэт цаасны тухай хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.

3.1.2. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах.

3.1.3. Үнэт цаасны зах зээлийн талаар нийтэд сурталчлах, холбогдох мэдээ, мэдээллийг зохих хууль, журмын дагуу хөрөнгө оруулагчид өгөх.

3.1.4. Үнэт цаасны зах зээл дээр өөртөө оногдсон ажил үүргийг ил тод, шударга гүйцэтгэх.

3.1.5. Байгууллага, иргэдээс гаргасан санал, өргөдөл, гомдлыг шуурхай шалган шийдвэрлэх.

3.1.6. Дотоод мэдээллийн нууцыг хадгалах.

ДӨРӨВ. Дотоод мэдээлэл эзэмшигчид

хориглох үйл ажиллагаа

4.1. Хорооны ажлын албаны мэргэжилтэн, Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчид дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

4.1.1. Дотоод мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, бусдад дамжуулах;

4.1.2. Албан тушаалаа ашиглан бусад байгууллага, иргэнд нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэх;

4.1.3. Хөрөнгө оруулагч болон зуучлагчийн ашиг сонирхолд автагдаж, хууль зөрчсөн үйл ажиллагааг ямар нэг хэлбэрээр дэмжих;

4.1.4. Бусдын ашиг сонирхлын үүднээс Хорооноос гарах шийдвэрт нөлөөлөх;

4.1.5. Байгууллага, иргэдэд буруу ташаа мэдээлэл, тайлбар өгөх, тэдгээрийг төөрөгдүүлэх;

4.1.6. Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаатай холбогдуулан Хорооноос баталсан удирдамж, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу хийсэн шалгалтын тайлан болон хуулийн байгууллагад өгсөн тайлбар, шинжээчийн дүгнэлтэд орсон дотоод мэдээлэлд хамаарах мэдээ, баримтыг бусдад мэдээлэх, тараах.

4.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох ажилтанд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

4.2.1. Хувийн болон бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс бусдад нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэх;

4.2.2. Харилцагчийн овог, нэр, хаяг, иргэний паспортын сери дугаар, регистр, төвлөрсөн хадгаламжид нээлгэсэн дансны дугаар, түүнд байршуулсан үнэт цаас болон мөнгөний тоо хэмжээ, түүний гүйлгээний талаар зуучлагч байгууллагын холбогдох мэргэжилтэн, итгэмжлэгдсэн этгээд бусад байгууллага, хүмүүст мэдээлэх;

4.2.3. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нууцын зэрэглэлд

хамаарах ажлын болон судалгааны файлууд, албан ажлын мэдээ тайланг ажил үүргийн зориулалтаас гадуур хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын үүднээс бусдад танилцуулах, хувилж тараах, тэдгээрийн агуулгын талаар мэдээлэх;

4.2.4. Байгууллага, иргэдэд хуурамч бичиг баримт бүрдүүлж өгөх, маргаантай асуудлын талаар бодитой бус дүгнэсэн тайлбар, тодорхойлолт гаргах;

4.2.5. Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн бүртгэл тайланг зориудаар будлиулах, баримтыг үрэгдүүлэх, нөхөж үйлдэх, тэдгээрт засвар өөрчлөлт оруулах;

4.2.6. Үнэт цаасны зах зээлийн талаар бодитой бус мэдээлэл тараах, хөрөнгө оруулагч болон зуучлагч байгууллагын нэр хүндэд хохирол учруулах.

4.3. Брокер, дилерийн компани, андеррайтер, Хөрөнгө оруулалтын сангийн эрх бүхий албан тушаалтан, менежер, дилер, брокер, тэдгээрийн итгэмжлэгдсэн этгээдэд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

4.3.1. Үйлчлүүлж байгаа харилцагчийн захиалгын гэрээний үзүүлэлтүүд, дансны гүйлгээг эзнээс нь өөр хүмүүст мэдээлэх, холбогдох баримтыг бусдад дамжуулах;

4.3.2. Мэдээллийн давуу байдлаа ашиглах, харилцагчид үнэт цаасаа алдагдалтай худалдахыг төөрөгдүүлэн зөвлөх;

4.3.3. Харилцагчийн захиалгын гэрээ болон холбогдох бусад баримтыг хуурамчаар үйлдэх;

4.3.4. харилцагчийн үнэт цаас, мөнгийг хувьдаа ашиглах, завших;

4.3.5. Харилцагчийн зөвшөөрөлгүйгээр түүний данснаас аливаа гүйлгээ хийх;

4.3.6. Үнэт цаасны нь үнэ ханш, арилжаанд нөлөөлөх аливаа үйлдэл хийх;

4.3.7. Харилцагчид буруу ташаа мэдээлэл өгөх, тэдгээрийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх үйлдэл хийх, ятгах, дарамт шахалт үзүүлэх;

4.3.8. Харилцагчийн тухай цуурхал, буруу ташаа мэдээг нийтэд тараах;

4.3.9. Харилцагчийн өмчлөлд буй үнэт цаасыг түүний зөвшөөрөлгүй, захиалгагүйгээр арилжаанд оруулах.

4.4. Хувьцаат компанийн эрх бүхий албан тушаалтан, хянан шалгах зөвлөлийн гишүүн/хянан шалгагч/, бүртгэл, санхүүгийн болон архив, бичиг хэрэг хариуцсан ажилтанд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

4.4.1. Тухайн компанийн гаргасан үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтэд тарагдаагүй мэдээллийг хувийн болон бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, бусдад дамжуулах;

4.4.2. Нийтэд санал болгож гаргахаар бэлтгэж байгаа үнэт цаастай холбогдох хөрөнгө оруулалтын төсөл, тохиролцоонд хүрсэн болон байгуулсан гэрээ хэлцлийн нууцыг хувийн болон бусад ашиг сонирхолд ашиглах, бусдад дамжуулах;

4.4.3. Хувьцаат компанийн нууцад хамаарах мэдээлэл, үнэт цаасны дотоод мэдээллийн нууцыг задруулах, бусдад дамжуулах.

ТАВ. Хүлээлгэх хариуцлага

5.1. Энэ журмаар тогтоосон үүргээ биелүүлээгүй, хориглосон үйл ажиллагаа явуулсан дотоод мэдээлэл эзэмшигчид Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан захиргааны шийтгэл ногдуулна.